



46 25

**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2008 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

**УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН
ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2008 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ:**

Нэг. Улаанбаатар хотын 2008 оны аварга шалгаруулах Уран сайхны гимнастикийн тэмцээнийг 2008 оны 04 дүгээр сарын 05-06-ны өдөр Спорт цогцолборын Гимнастикийн зааланд зохион байгуулсугай.

Хоёр. Тэмцээний зааврыг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, зохион байгуулахад шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 417.000 /дөрвөн зуун арван долоон мянга/ төгрөгийг биеийн тамир, спортын арга хэмжээний зардлаас гаргахыг ня-бо /Ж.Цэдэнсодном/-д зөвшөөрсүгэй.


Дөрөв. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /О.Болор-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.



Ж.ГАНБОЛД

42 8

НБТСХ-ны даргын 2008 оны 03 дугаар сарын
24-ны өдрийн 16 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

1. Зорилго

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 246 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх, нийслэлийн хүүхэд, залуучуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, уран сайхны гимнастикийн тамирчдын амжилтыг дээшлүүлэх, өндөр ур чадвартай тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.

2. Зохион байгуулах газар, хугацаа

Уран сайхны гимнастикийн 2008 оны Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн 2008 оны 04 дүгээр сарын 5-ны өдрийн 10.00 цагт Спорт цогцолборын гимнастикийн зааланд зохион байгуулагдана.

3. Оролцох байгууллага, хүмүүс

Тэмцээнд Нийслэлийн Дүүргийн Биеийн тамир, спортын хороодын баг тамирчид, уран сайхны гимнастикаар хичээллэгч бүх тамирчид оролцоно.

Тэмцээний заавар

4-р сарын 5-ны өдөр:

Охидын 1, 2, 3-р зэрэг

Насанд хүрэгчдийн 1, 2, 3-р зэрэг

Спортын дэд мастерийн зэргээр оролцож байгаа баг тамирчид заавлын хөтөлбөрт дасгалаар тэмцээнд оролцоно. Заавлын хөтөлбөрт дасгалыг 10 онооноос шүүж явуулна.

4-р сарын 6-ны өдөр:

1-р зэрэг

Спортын дэд мастер

Спортын мастер


ОУХМастерийн зэргээр оролцож байгаа тамирчид хувийн хөтөлбөрт дасгалаар өрсөлдөнө. Хувийн хөтөлбөрт дасгалыг Олон улсын дүрмийн дагуу шүүж явуулна.

4. Дүгнэх журам

Тэмцээний зэрэг тус бүрийн хамгийн өндөр оноотой тамирчдыг эхний гурван байрт шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнана. Тэмцээний техникийн зөвлөлгөөн 2008 оны 4-р сарын 3-ны 12.00 цагт Нийслэлийн Биеийн тамир, спортын хорооны байранд зохион байгуулагдана.

**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ХОРОО**

45 127
НБТСХ-ны даргын 2008 оны 03 дугаар сарын
24-ны өдрийн 16 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт




**УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН
ТЭМЦЭЭНИЙ ШҮҮГЧДИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

| № | Шүүгчдийн овог, нэр | Байгууллага | Гүйцэтгэх үүрэг | Зэрэг |
|-----|---------------------|-------------|-----------------------|-------|
| 1. | А.Болдмаа | МГХ | Ерөнхий шүүгч | УШ |
| 2. | С.Ганцэцэг | МГХ | Нарийн бичиг шүүгч | УШ |
| 3. | Б.Номин | МГХ | Шүүгч | УШ |
| 4. | Ш.Оюунчимэг | МГХ | Шүүгч | УШ |
| 5. | Х.Үржинсүрэн | МГХ | Шүүгч | УШ |
| 6. | Н.Хүрлээ | МГХ | Шүүгч | УШ |
| 7. | Ж.Цэрэндулам | МГХ | Шүүгч | УШ |
| 8. | Ч.Отгонцэцэг | МГХ | Шүүгч | УШ |
| 9. | Д.Хишгээ | МГХ | Шүүгч | УШ |
| 10. | Б.Булган | МГХ | Шүүгч | УШ |
| 11. | Т.Батбагана | МГХ | Шүүгч | УШ |
| 12. | Б.Халиун | МГХ | Шүүгч | УШ |
| 13. | Л.Туяа | МГХ | Шүүгч | УШ |
| 14. | О.Болор-Эрдэнэ | МГХ | Шүүгч | УШ |
| 15. | Н.Гиймаа | МГХ | Шүүгч | УШ |

49 38

НБТСХ-ны даргын 2008 оны 03 дугаар сарын
24-ны өдрийн 16 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



**УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ**

| № | Зардлын нэр | Нийт дүн |
|-------------|--|--------------------|
| 1. | Тамирчдын шагнал: 1-р байр: 8 x 6000 төг = 48000 төгрөг 2-р байр: 8 x 5000 төг = 40000 төгрөг 3-р байр: 8 x 4000 төг = 32000 төгрөг | 120.000 |
| 2. | Шүүгчдийн ажлын хөлс: /15 хүн x 2 өдөр x 5.000 төг/ | 150.000 |
| 3. | Заал, талбайн хөлс: | 50.000 |
| 4. | Дипломын үнэ /27 ш/ | 15.000 |
| 5. | Медалийн үнэ /27 ш/ | 82.000 |
| ДҮН: | | 417.000 төг |